

МОНГОЛ УЛС,

**ЕВРОПЫН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХОЛБООНЫ
ГИШҮҮН ОРНУУД ХООРОНДЫН**

**ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХАМТАРСАН
ТУНХАГЛАЛ**

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХАМТАРСАН ТУНХАГЛАЛ

Нэг талаас Монгол Улс,

Нөгөө талаас Бүгд Найрамдах Исланд Улс, Лихтенштейны Вант Улс, Норвегийн Вант Улс болон Швейцарийн Холбооны Улс (цаашид “ЕЧХХ-ны гишүүн орнууд” гэх),

Монгол Улс болон ЕЧХХ-ны гишүүн орнууд хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улам бүр хөгжүүлэхийг эрмэлзэн,

Хүний эрхийн үндсэн зарчмууд, хүмүүс хоорондын болон эдийн засгийн хил дамнасан харилцааг хөгжүүлэх нийтлэг зорилгод тулгуурлан,

Монгол Улс болон ЕЧХХ-ны гишүүн орнууд хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны харилцааг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэлийг нотолж,

Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын өмнө хүлээсэн үүрэг, амлалтанд үндэслэн,

Монгол Улс болон ЕЧХХ-ны гишүүн орнууд хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх, нэр төрлийг нь олшруулах хүрээ бий болгох эрмэлзлэлээ тунхаглан,

Бусад салбарт хамтын ажиллагааг бэхжүүлэх боломжийг эрэлхийлэхийг хүсч,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

I. ЗОРИЛГО

1. Монгол Улс болон ЕЧХХ-ны гишүүн орнууд нь:

- (a) Талуудын хоорондын эдийн засгийн харилцаа, ялангуяа бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- (b) Талуудын худалдаа, бизнесийн хамтын ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоо, ялангуяа жижиг, дунд үйлдвэрийн оролцоог нэмэгдүүлэхийг дэмжих;
- (c) Холбогдох салбарын хүрээнд талуудын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх цаашдын боломжийг судлахыг эрэлхийлнэ.

II. ХУДАЛДАА

2. Монгол Улс болон ЕЧХХ-ны гишүүн орнууд нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, ялангуяа ДХБ-ын хэлэлцээрүүдийн заалтыг харгалзан өөрсдийн худалдааны харилцааг өргөжүүлэх тодорхой арга хэрэгслийг эрэлхийлнэ. Тухайлбал:

- (a) Худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгах;
- (b) Гаалийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- (c) Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний гадаад худалдааны асуудлаар мэдээлэл солилцох;
- (d) Энэхүү тунхаглалын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд худалдааны бодлогын боломжит бүх хэрэгслүүдийг судлах.

3. Монгол Улс болон ЕЧХХ-ны гишүүн орнууд нь өөрсдийн худалдааны харилцааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой салбаруудад хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг эрэлхийлнэ. Тухайлбал:

(a) Чөлөөт, шударга өрсөлдөөний асуудлаар санал солилцох;

(b) Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах ажиллагааны талаар мэдээлэл солилцох;

(c) Оюуны өмчийг хамгаалах салбарт хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих.

4. Монгол Улс болон ЕЧХХ-ны гишүүн орнууд нь худалдааны харилцаагаа хөгжүүлэх зорилгоор бизнесийн харилцаа холбоо, ялангуяа гадаад худалдаатай холбоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын хооронд харилцаа холбоо тогтоохыг хөхиүлэн дэмжиж, эрчимжүүлнэ.

III. ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

5. Монгол Улс болон ЕЧХХ-ны гишүүн орнууд нь харилцан сонирхсон эдийн засгийн бүх салбарт хөрөнгийн урсгал, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх таатай нөхцлийг бий болгох, түүнчлэн оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалах замаар хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх нөхцлийг сайжруулахыг эрмэлзэнэ.

IV. ХАМТАРСАН ХОРОО

6. Монгол Улс болон ЕЧХХ-ны гишүүн орнууд нь үүгээр Хамтарсан хороо байгуулав.

7. Хамтарсан хороо нь энэхүү тунхаглалд дурьдсан салбарт хамтын ажиллагааг хянан үзэж, хамтын сонирхлын бусад асуудлыг хэлэлцэнэ. Хамтарсан хороо нь Монгол Улс болон ЕЧХХ-ны гишүүн орнуудын хоорондын хамтын ажиллагааны аливаа асуудлаар зохих зөвлөмж гаргана.

8. Талууд шаардлагатай гэж үзвэл харилцан тохиролцсоны үндсэн дээр Хамтарсан хороог хуралдуулна. Талууд хоорондоо тохирч видео-хурал зохион байгуулж болно.

9. Хамтарсан хорооны Нарийн бичгийн дарга нарын үүргийг Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яам болон ЕЧХХ-ны гишүүн орнуудын Нарийн бичгийн дарга нарын газар хамтран гүйцэтгэнэ.

2007 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Вадуц хотноо монгол, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд бүгд адил хүчинтэй байна. Тунхаглалыг тайлбарлах явцад зөрүү гарвал англи хэлээрх бичвэрийг баримтална.

Монгол Улсыг төлөөлж:

.....

Бүгд Найрамдах Исланд Улсыг төлөөлж:

.....

Лихтенштейны Вант Улсыг төлөөлж:

.....

Норвегийн Вант Улсыг төлөөлж:

.....

Швейцарийн Холбооны Улсыг төлөөлж:

.....